



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.04.20 № 321

танай _____ ны № _____ т

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Б.АРИУН-ЭРДЭНЭ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу аймгийн ТЕЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган аймгийн ТЕЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орон нутгийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдэж байсан тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага Эрүүл мэндийн төвийн 16, Ерөнхий боловсролын сургуулийн 23, Цэцэрлэгийн 22, Соёлын төвийн 18 нийт 79 байгууллага нь харьяа төсвийн ерөнхийлөн захирагчид шилжсэнээр 2022 оны санхүүгийн нэгдсэн тайлангийн үндсэн хөрөнгө 73,741.6, бараа материал 11,561.5, авлага 2,513.8 сая төгрөгөөр өмнөх оны үлдэгдлээс тус тус буурснаар илэрхийлэгдэж байна.

Аудитын гол асуудал

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор “Төрийн хэмнэлтийн тухай” хууль, “Алсын хараа-2050” урт хугацааны бодлого, Шинэ сэргэлтийн бодлогын үзэл баримтлалд нийцүүлж аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөрийн зарим зорилт, арга хэмжээнд өөрчлөлт оруулахаар тооцоо судалгааг хийж ажиллаж үүрэг чиглэлээр

006020324

ханган ажилласан ч зарим орон нутгийн төсөвт байгууллагууд төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аймгийн Засаг дарга 2022 оны хөгжлийн төлөвлөгөөг 4 бодлогын хүрээнд 5 зорилт дэвшүүлж, 95 арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөн батлуулж гүйцэтгэлээр 90 ажил нь бүрэн хийгдэж 5 ажил нь дутуу хэрэгжсэнээр биелэлт 84.4 хувиар аймгийн ИТХ-ын XII хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 03-ны өдөр хэлэлцэж дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ